



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН НЭР: МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2021 ОНЫ
СОНГУУЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДУУЛАН
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГТ УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН
ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТАД АУДИТ ХИЙЖ, ДҮГНЭЛТ
ГАРГАХ**

АУДИТЫН КОД: БӨА-2021/04/ШТА-ГА

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ ЗОХИОН
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН
ТӨСВИЙГ ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛЖЭЭ**

Баян-Өлгий аймаг 2021 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 цахим хуудас:
Khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 цахим хуудас:
jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Х.Еркебулан

Утас: 99999844 Цахим
хуудас: erkebulankh@audit.gov.mn

Аудитор Р.Баярмаа

Утас: 99265539 Цахим хуудас
bayarmaar@audit.gov.mn

Энэхүү аудиттай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас:
www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5-6

БҮЛЭГ 1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, хуваарилсан байна.....	7
--	---

1.1 Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна.	7
---	---

1.2. Сонгуулийн хороодод зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилжээ....	8
--	---

БҮЛЭГ 2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг 10176.8 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.....	9
---	---

2.1 Батлагдсан төсвийг нийт дүнгээр 10176.8 мянган төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна.	9-11
--	------

2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой зөв тайлагнасан байна.....	11-12
---	-------

2.3 Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.....	12-13
--	-------

ДҮГНЭЛТ:.....	14
---------------	----

Холбогдох байгууллагын санал:	15
-------------------------------------	----

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
МТБ	Үндэсний аудитын газар
МТБ	Мэдээлэл технологийн баг
САС	Сонгуулийн автоматжуулсан систем
ЖМС	Жижиг мөнгөн сан

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	2021 оны сонгуулийн хуваарилагдсан төсвийн судалгаа	7
Хүснэгт 2	Баян-Өлгий аймгийн Сонгуулийн хорооны төсвийн хуваарилалт	8
Хүснэгт 3	Батлагдсан төсвийн хэтрэлт, хэмнэлтийн судалгаа	9-10
Хүснэгт 4	Сонгуулийн зардлын хуваарилагдсан төсөв, гүйцэтгэл	10-11
Хүснэгт 5	Сонгуулийн хорооны нийт зардлын гүйцэтгэл	12

Аудит хийх үндэслэл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8¹, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 4.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн Баян-Өлгий аймгийн сонгуулийн хорооны зардлын тайланд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3²-т заасныг баримтлан гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт

Сонгууль зохион байгуулахтай холбогдсон Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн 2021 оны сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан СЕХ-ноос Баян-Өлгий аймгийн сонгуулийн хороонд хуваарилан зарцуулсан хөрөнгийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын баримт материалуудыг хамруулан хэрэгжүүллээ.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-1, 6817-5, 6817-7, Гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан шалгадагч болон хамрагдагч байгууллагын сонгуулийн зардлын тайлан, холбогдох баримт материалыг шалгах, асуулга лавлагаа, тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх, харьцуулах, нэгтгэх, зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж, төлөвлөсөн арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад дараах хууль эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль

¹ Хуулийн 9.8-д Энэ хуулийн 9.1, 9.2, 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.7-д заасан зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд төрийн аудитын дээд байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу хяналт тавьж, аудит хийж, дүгнэлт гаргана.

² Хуулийн 6.3. Төрийн аудитын байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.3.1. шалгадагч этгээдэд энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх;

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

- СЕХ-ны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”
Бусад холбогдох хууль тогтоомжууд

Аудитыг аудитор Х.Еркебулан, Р.Баярмаа нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг гүйцэтгэж, дарга бөгөөд тэргүүлэх аудитор М. Хуанган хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек нар чанарын хяналтыг хэрэгжүүлэв.

Аудитын талбарын ажлыг 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулав.

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ ЗАРДЛЫГ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН БАЙНА

1.1. Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна

Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооны 2021 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн А/17 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.1³ дэх хэсэгт заасны дагуу Сонгуулийн Ерөнхий хорооны ажлын албаны 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 3/124 дүгээр албан бичгийн 2 дугаар хавсралтаар Баян-Өлгий аймагт 656521.9 мянган төгрөгийн төсөв хуваарилсан байна. Үүнд:

Хүснэгт №1		/төгрөг/
№	Хуваарилагдсан зардлын нэр	Хуваарилагдсан төсөв
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	250000
2	Бичиг хэргийн зардал	14720000
3	Шуудан, холбооны зардал	17500000
4	Унааны зардал	54800000
5	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	3552000
6	МТБ, даамлын сургалтын зардал	12180000
7	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	2000000
8	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	31040000
9	Сурталчилгааны зардал	5000000
10	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, буцаан хүргэх зардал	28984000
11	САС ашиглахтай холбоотой гарах зардал /Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх/	4365000
12	Томилолтын зардал	5880900
13	Мэдээ дамжуулах унааны зардал	3960000
14	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	405740000
15	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	56550000
16	Болзошгүй зардал	10000000
Нийт дүн		656521900

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн Сонгуулийн хорооны батлагдсан төсөв

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн тус аймгийн Сонгуулийн хорооны 2021 оны төсвийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн 2017 оны төсөвтэй харьцуулж үзэхэд 2021 оны сонгуулийн төсөв 2017 оноос 192856.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

1.2. Сонгуулийн хороодод зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилжээ

Аймгийн Сонгуулийн хорооны 2021 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах сумдын Сонгуулийн хороог байгуулж, СЕХ-оос хуваарилсан хөрөнгийг “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журмын 2.34 дэх хэсэгт заасны дагуу хуваарилжээ.

Аймгийн Сонгуулийн хорооны 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 3/71, 05 дугаар сарын 12-ний өдрийн 3/103, 05 дугаар сарын 31-ний өдрийн 3/124 дугаар албан бичгүүдээр сонгуулийн зардлын санхүүжилтийг хэрхэн хуваарилсан тухай тайлбар, төсвийн хуваарийг тус тус хүргүүлсэн байна.

СЕХ-оос хуваарилагдсан 656521.9 мянган төгрөгийн төсвийн 495587.4 мянган төгрөгийг сумдын Сонгуулийн хорооны үйл ажиллагаанд, 160934.5 мянган төгрөгийг аймгийн Сонгуулийн хорооны үйл ажиллагааны зардалд тус тус хуваарилсан байна.

Хүснэгт №2

/төгрөг/

№	Сумын нэр	Хэсгийн тоо	Бичиг хэрэг	Шуудан холбоо	Санал авах байр бэлтгэх	Унааны зардал	Урамшуулал, Хоолны мөнгө	Даамалуудын урамшуулал хоолны мөнгө	ДҮН
1	Алтай	5	760,000	900,000	1,450,000	1,854,000	19,989,000	2,538,000	27,491,000
2	Алтанцөгц	4	640,000	750,000	1,160,000	774,000	13,644,000	2,115,000	19,083,000
3	Баяннуур	5	760,000	900,000	1,450,000	2,065,600	19,989,000	2,538,000	27,702,600
4	Бугат	5	760,000	900,000	1,450,000	1,030,000	17,451,000	2,538,000	24,129,000
5	Булган	7	1,000,000	1,200,000	2,030,000	4,016,400	26,757,000	3,384,000	38,387,400
6	Буянт	4	640,000	750,000	1,160,000	1,274,800	13,644,000	2,115,000	19,583,800
7	Дэлүүн	12	1,600,000	1,950,000	3,480,000	4,258,400	39,024,000	5,922,000	56,234,400
8	Ногооннуур	9	1,240,000	1,500,000	2,610,000	4,332,800	32,679,000	4,653,000	47,014,800
9	Сагсай	7	1,000,000	1,200,000	2,030,000	3,735,600	25,065,000	3,384,000	36,414,600
10	Толбо	6	880,000	1,050,000	1,740,000	1,489,800	23,796,000	2,961,000	31,916,800
11	Улаанхус	11	1,480,000	1,800,000	3,190,000	4,255,400	36,063,000	5,499,000	52,287,400
12	Цэнгэл	9	1,240,000	1,500,000	2,610,000	4,842,200	34,371,000	4,653,000	49,216,200
13	Өлгий	13	1,720,000	2,100,000	3,770,000	1,746,400	50,445,000	6,345,000	66,126,400
14	Аймгийн Сонгуулийн хороо	0	1,250,000	1,000,000	7,275,000	90,681,500	52,823,000	7,905,000	160,934,500
ДҮН		97	14,970,000	17,500,000	35,405,000	126,356,900	405,740,000	56,550,000	656,521,900

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн Сонгуулийн хорооны төсвийн хуваарилалт

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын төсвийг сумуудын хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, хэсгийн хороодын тоо зэрэг мэдээлэлд үндэслэж хуваарилсан байна.

Сонгуулийн Ерөнхий хорооноос хуваарилсан нийт төсвийн 75.5 хувийг буюу 495587.4 мянган төгрөгийг сумдын Сонгуулийн хороонд, 24.5 хувийг буюу 160934.5 мянган төгрөгийг аймгийн Сонгуулийн хороонд хуваарилсан байна.

БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА

2.1. Батлагдсан төсвийг нийт дүнгээр 10176.8 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар хэмнэлттэй зарцуулсан байна

Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооноос Баян-Өлгий аймгийн Сонгуулийн хороонд төлөвлөсөн нийт 656521.9 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн Ерөнхий хорооноос 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр 129737.0 мянган төгрөгийн, 05 дугаар сарын 12-ны өдөр 54494.9 мянган төгрөгийн, 05 дугаар сарын 31-ний өдөр 472290.0 мянган төгрөгийн, нийтдээ 656521.9 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус хүлээн авсан байна.

Баян-Өлгий аймгийн Сонгуулийн хороо гүйцэтгэлээр нийтдээ 646345.1 мянган төгрөгийг зарцуулж, төсвөө 10176.8 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар хэмнэж, хэмнэгдсэн хөрөнгийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлжээ.

Сонгуулийн зардлын гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар харуулав.

Хүснэгт №3

/төгрөг/

№	Хуваарилагдсан зардлын нэр	Хуваарилагдсан төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	250000	250000	
2	Бичиг хэргийн зардал	14720000	14720000	
3	Шуудан, холбооны зардал	17500000	17500000	
4	Унааны зардал	54800000	54800000	
5	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	3552000	3022410	529590
6	МТБ, даамлын сургалтын зардал	12180000	6154680	6025320
7	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	2000000	1750000	250000
8	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	31040000	31040000	
9	Сурталчилгааны зардал	5000000	5000000	
10	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, буцаан хүргэх зардал	28984000	28984000	
11	САС ашиглахтай холбоотой гарах зардал /Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх/	4365000	4365000	
12	Томилолтын зардал	5880900	5880900	
13	Мэдээ дамжуулах унааны зардал	3960000	3960000	
14	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	405740000	404894000	846000

15	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	56550000	54050000	2500000
16	Болзошгүй зардал	10000000	9974100	25900
Нийт дүн		656521900	646345090	10176810

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн Сонгуулийн хорооны зардлын тайлан

Үүнд сонгуулийн хорооны гишүүдийн сургалтын зардлаас 529.6 мянган төгрөг, МТБ, даамлын сургалтын зардлаас 6025.3 мянган төгрөг, МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардлаас 250.0 мянган төгрөг, Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардлаас 846.0 мянган төгрөг, мэдээлэл технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардлаас 2500.0 мянган төгрөг, болзошгүй зардлаас 25.9 мянган төгрөгийг тус тус хэмнэж, маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал, бичиг хэргийн зардал, шуудан, холбооны зардал, унааны зардал, санал авах байр, төрийн далбаа бэлтгэх зардал, сурталчилгааны зардал, саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, буцаан хүргэх зардал, САС ашиглахтай холбоотой гарах зардал /Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх/, томилолтын зардал, мэдээ дамжуулах унааны зардлуудыг төсөвтөө багтаан зарцуулсан байна.

Аймаг, сумын Сонгуулийн хороод нь аймаг, сумын төрийн санд сонгуулийн зардлын дансыг тус тусдаа нээж, төсвөөс олгосон санхүүжилтийг хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийн дагуу зарцуулсан байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн Ерөнхий хорооноос нийтдээ 656521.9 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч сумдын Сонгуулийн хороонд 495617.4 мянган төгрөгийг, Аймгийн Сонгуулийн хорооны үйл ажиллагаанд 160904.5 мянган төгрөгийг тус тус шилжүүлжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд улсын төсвөөс олгосон санхүүжилтийг Сонгуулийн Ерөнхий хорооны Ажлын албаны 2021 оны 3/71, 3/103, 3/124 дүгээр албан бичгээр ирүүлсэн аргачлал, зөвлөмжийн дагуу аймгийн Сонгуулийн хорооны даргын тушаалаар аймаг, сумдын Сонгуулийн хороодод зардлын зүйл ангиар хуваарилж, санхүүжүүлсэн байна.

Сонгуулийн хороодын төсвийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №4

/мянган төгрөг/

д/д	Аймгийн сонгуулийн хорооны нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт, хэтрэлт
1	Алтай сум	27491.0	27491.0	-
2	Алтанцөгц сум	19083.0	19083.0	-
3	Баяннуур сум	27702.6	27702.6	-
4	Бугат сум	24129.0	24129.0	-
5	Булган сум	38387.4	38387.4	-
6	Буянт сум	19583.8	19583.8	-
7	Дэлүүн сум	56234.4	56234.4	-
8	Ногооннуур сум	47014.8	46168.8	846.0
9	Сагсай сум	36414.6	36414.6	-
10	Толбо сум	31916.8	31916.8	-

11	Улаанхус сум	52287.4	52287.4	-
12	Цэнгэл сум	49216.2	49216.2	-
13	Өлгий сум	66126.4	66126.4	-
14	Аймгийн төв	160934.5	151603.7	9330.8
	Аймгийн дүн	656521.9	646345.1	10176.8

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн Сонгуулийн хорооны зардлын тайлан

Аймгийн Сонгуулийн хороо үйл ажиллагаанд нийт 151573.7 мянган төгрөгийг зарцуулж, төсвөө 9330,8 мянган төгрөгөөр хэмнэж, Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Үүнд сонгуулийн хорооны гишүүдийн сургалтын зардлаас 529.6 мянган төгрөг, МТБ, даамлын сургалтын зардлаас 6025.3 мянган төгрөг, МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардлаас 250.0 мянган төгрөг, Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардлаас 846.0 мянган төгрөг, мэдээлэл технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардлаас 2500.0 мянган төгрөг, болзошгүй зардлаас 25.9 мянган төгрөгийг тус тус хэмнэжээ.

Сумдын Сонгуулийн хороодоос Ногооннуур сумын сонгуулийн хороо төсвөө 846.0 мянган төгрөгөөр хэмнэж, бусад сумуудын Сонгуулийн хороод төсвөө бүрэн зарцуулсан байна.

Нийтдээ 9974.1 мянган төгрөгийн болзошгүй зардлаас КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 3074.4 мянган төгрөгийг сонгууль болох газруудыг ариутгал, хамгаалалт, халдваргүйжүүлэлт хийхэд зарцуулж, 6899.7 мянган төгрөгөөр халуун хэмжигч, гар ариутгагч, бээлий авсан байна.

2.2. Зардлын гүйцэтгэлийг бодитой зөв тайлагнасан байна

Аймгийн Сонгуулийн хороо Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд улсын төсвөөс олгосон зардлын тайланг сумуудын Сонгуулийн хороодоос хугацаанд нь хүлээн авч нэгтгэсэн тайланг гаргасан байна.

Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооны 2021 оны А/17 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 4.5 дахь хэсэгт заасны дагуу Баян-Өлгий аймгийн Сонгуулийн хорооны 2021 оны 07 дугаар сарын 02-ний өдрийн 1/30 тоот албан бичгээр Баян-Өлгий аймгийн Сонгуулийн хорооны сонгуулийн зардлын нэгдсэн тайланд дүгнэлт гаргуулахаар Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Аймаг, сумдын Сонгуулийн хороо нь хүлээн авч зарцуулсан сонгуулийн зардлын санхүүжилтийн тайланг нэгдсэн загварын дагуу гаргаж тайлагнаж, санхүүгийн баримтуудыг үдэж, архивласан байна.

Аймгийн Сонгуулийн хорооноос нэгтгэж гаргасан сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг аудитаар нэгтгэж гаргасан гүйцэтгэлтэй харьцуулбал дараах байдалтай байна.

Баян-Өлгий аймгийн Сонгуулийн хорооны нийт зардлын гүйцэтгэл

Хүснэгт №5

/төгрөг/

№	Зардлын нэр	Гүйцэтгэл /аймгийн Сонгуулийн хороо/	Гүйцэтгэл /Аудитаар/	Зөрүү
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	250000	250000	
2	Бичиг хэргийн зардал	14720000	14720000	
3	Шуудан, холбооны зардал	17500000	17500000	
4	Унааны зардал	54800000	54800000	
5	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	3552000	3022410	529590
6	МТБ, даамлын сургалтын зардал	12180000	6154680	6025320
7	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	2000000	1750000	250000
8	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	31040000	31040000	
9	Сурталчилгааны зардал	5000000	5000000	
10	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, буцаан хүргэх зардал	28984000	28984000	
11	САС ашиглахтай холбоотой гарах зардал /Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх/	4365000	4365000	
12	Томилолтын зардал	5880900	5880900	
13	Мэдээ дамжуулах унааны зардал	3960000	3960000	
14	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	405740000	404894000	846000
15	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	56550000	54050000	2500000
16	Болзошгүй зардал	10000000	9974100	25900
Нийт дүн		656521900	646345090	10176810

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн Сонгуулийн хорооны зардлын тайлан

Аймгийн Сонгуулийн хороо сонгуулийн зардлын гүйцэтгэлийг нийт дүнгээр зөв тайлагнажээ.

2.3 Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна

Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооны 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/17 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 1.2-д “... Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулж, харьяалах сонгуулийн хороодод хуваарилан, зарцуулалтад хяналт тавьж ажиллана” гэж заасан байна.

Мөн журмын 3.1 дэх хэсэгт “Сонгуулийн ерөнхий хороо нь аймаг нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын дансыг Сангийн яамны Төрийн сангийн газарт нээлгэн, сонгууль дууссаны дараа зохих журмын дагуу хаалгана” гэж заасны дагуу СЕХ-ны ажлын албаны 2021 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 3/71 дүгээр албан бичгийн 1-р хавсралтаар баталсан “Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны төсвийн хуваарийн тухай тайлбар”-аар Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны зардлын дансыг Төрийн санд нээлгэсэн бөгөөд арилжааны банканд давхар данс /харилцах болон ЖМС-ийн данс/ нээлгэхийг хориглох чиглэл өгчээ.

Аймаг, сумын Сонгуулийн хороод төсвөөс олгосон санхүүжилтийг Төрийн сан дахь харилцах дансаар хүлээн авч сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Журмын 3.10 дахь хэсэгт заасны дагуу Сонгуулийн Ерөнхий Хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын төсвийн зарцуулалтад, аймгийн Сонгуулийн хороо нь сумдын Сонгуулийн хорооны сонгуулийн зардлын төсвийн зарцуулалтад тавих хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Аймгийн Сонгуулийн хорооноос сумуудын болон хэсгийн хороо сонгуулийг зохион байгуулах бэлтгэл ажил нь хангагдсан эсэх талаар явцын хяналт хийж, алдаа дутагдлыг тухай бүрд арилгаж ажилласан ба сумуудын зардлын тайланг журмын 4.4 дэх хэсэгт заасны дагуу хүлээж авсан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна.
2. Аймаг, сумын Сонгуулийн хороодын зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.
3. Батлагдсан төсвийг нийт дүнгээр 10.2 сая төгрөгөөр хэмнэсэн байна.
4. Сонгуулийн зардлын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнасан байна.
5. Сонгуулийн төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг зохих журмаар байна.

Холбогдох байгууллагын санал:

Аймгийн Сонгуулийн хорооны санал


**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**
83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/факс: (976) 7042-2595

2021.07.27 № 1/31
танай _____-ны № _____-т

**АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны
ээлжит сонгуулийн зардлын тайланд хийсэн
аудитын тайлангийн төсөлтэй танилцав.

Дээрх аудитын дүгнэлтэд санал нэг байна.

ДАРГА  Ө.ХУРАЛАЙ

://by documents/h blank A5/book.doc
00000051



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2021 оны 07 сарын 29 өдөр

Дугаар А/15

Өлгий

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1 20.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, 2018 оны А/207 дугаар “Эрх үүрэг шилжүүлэх” тушаалын 5 дугаар хавсралтын 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн Баян-Өлгий аймгийн сонгуулийн зардлын гүйцэтгэл” сэдвээр хийсэн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлсүгэй.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР **М.ХУАНГАН**

D:\bichia herea\2021\tushaal.doc